

**НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ХОРООНЫ
2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

1. *Төлөвлөгөө*: НМХГ-ын Ёс зүйн хороо нь байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2018 оны төлөвлөгөөг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Ёс зүйн хорооны 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан.

2. *Сургалт*: Албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн улсын /ахлах/ байцаагчдад, 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Сүхбаатар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын /ахлах/ байцаагчдад зориулан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан. Мөн тус газрын 484 албан хаагчдаар “Ёс зүйн мэдэгдэл”-ийг гаргуулан баталгаажуулж, албан хаагчдын хувийн хэрэгт хавсарган баяжилт хийсэн.

3. *Сурталчилгаа*: НМХГ-ын цахим хуудсанд 2018 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчлийн мэдээ, ёс зүйн хорооны үйл ажиллагааны тайланг шинэчлэн байршуулсан.

4. *Ёс зүйн зөрчлийн талаар*: 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар улсын байцаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гэх 28 асуудлыг судлан шалгаж 7 удаагийн хурлыг зарлан хуралдуулж Ёс зүйн хорооны 9 дүгнэлт гарсан байна. /хүснэгт 1/.

Хүснэгт 1

№	Гомдол гаргасан, иргэн аж ахуйн нэгжийн нэр	Зөрчил гаргасан улсын /ахлах/ байцаагчийн нэр	Гомдлын агуулга	Шийдвэрлэсэн байдал
1	Цагаан Арал ХХК	ДБХХ-ийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч О.Сүнжидмаа	ДБХХ-ийн Барилгын техникийн улсын байцаагч О.Сүнжидмаа ...ёс зүйгүй, тухайн салбарын техникийн нэр томъёо хэллэгийг мэддэггүй, мэдлэг чадваргүй, ашиг сонирхлын зөрчилтэй, төрийн албан хаагчийн нэр хүндийг гутааж байна...	2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Ёс зүйн хорооны 1 дүгээр хуралдаанаар улсын байцаагч О.Сүнжидмаатай холбоотой асуудлыг хэлэлцүүлэн 18/01 дугаартай дүгнэлт гаргасан.
2	Гомдол гаргагч тодорхойгүй	БГД дэх МХХ-ийн дарга Б.Нарангэрэл	БГД дэх МХХ-ийн дарга Б.Нарангэрэл нь ...ажлын ур чадвар, удирдан зохион байгуулах авьяас чадваргүй, хувийн зан чанар, ухамсарын түвшин дорой, ...хийж байгаа үйлдлүүд нь төрийн албан хаагчийн нэр хүндийг гутааж байна...	Тус гомдлыг судлаж шалгах явцад ёс зүйн хорооны гишүүдээс нэмэлт ажиллагаа явуулахад БГД дэх МХХ-ийн гомдол гаргагч улсын байцаагчид тодорхойгүй байсан тул уг асуудлыг хэлэлцүүлээгүй болно.
3	Удирдлагаас ирүүлсэн шийдвэрийн дагуу	СХД дэх МХХ-ийн Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч	СХД дэх МХХ-ийн Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Гэрэлчимэг ...төрийн албан хаагчийн ёс	2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Ёс зүйн хорооны 1 дүгээр хуралдаанаар улсын ахлах байцаагч

		Т.Гэрэлчимэг	зүйгүй тухай...	Т.Гэрэлчимэгтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлэн 18/02 дугаартай дүгнэлт гаргасан. Т.Гэрэлчимэгт Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтыг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулсан.
4	Удирдлагаас ирүүлсэн шийдвэрийн дагуу	ЭИХХЦХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Т.Жаргалмаа	Ёс зүйн зөрчилтэй гэх	2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн Ёс зүйн хорооны 2 дугаар хуралдаанаар улсын байцаагч Т.Жаргалмаатай холбоотой асуудлыг хэлэлцүүлэн 02/03 дугаартай дүгнэлт гарсан. Т.Жаргалмаад Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулсан.
5	БЗД 10-р хороо 1-р хэсэг 186 тоотод оршин суугч Д.Чимэдцэрэн	БЗД дэх МХХ-ийн ЭАХХХ-ын улсын байцаагч Д.Энхбат	Ёс зүйн зөрчилтэй гэх	2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Ёс зүйн хорооны 3 дугаар хуралдаанаар улсын байцаагч Д.Энхбаттай холбоотой асуудлыг хэлэлцүүлэн 03/04 дугаартай дүгнэлт гарсан.
6	Удирдлагаас ирүүлсэн шийдвэрийн дагуу	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн шуурхай ажлын албаны ажилтан Г.Ариунболд	Ёс зүйн зөрчилтэй гэх	2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Ёс зүйн хорооны 4 дүгээр хуралдаанаар Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн шуурхай ажлын албаны ажилтан Г.Ариунболдод холбоотой асуудлыг хэлэлцүүлж ёс зүйн зөрчилтэй гэх нь нотлогдоогүй болно.
7	ХУД-ийн 4-р хороо Арцад 1-ийн 55 тоотод оршин суугч Г.Цэнд	ХУД дэх МХХ-ийн Мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Болдбаатар	Мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Болдбаатарт гомдол гаргаж байна. Малтай айлуудыг хотоос гаргаж байгаа талаар сонссон боловч тэр захирамжийг	2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Ёс зүйн хорооны 5 дугаар хуралдаанаар ХУД дэх МХХ-ийн Мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Болдбаатарт

			нь хараагүй бөгөөд албан ёсоор ирж танилцуулаагүй. ...Үхэр тугалаа нийлүүлээд хотоос гаргая гэхээр торгуулийн 50000 төгрөг төл гэж байна. Би торгууль төлөх ёстойгоо ойлгохгүй байна.	холбогдох асуудлыг хэлэлцүүлэхэд ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүй болно.
8	УБ хотын Ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр	ЧД дэх МХХ-ийн байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Г.Цэцэгдэлгэр	МУ-ын ЗГ-ын мөрийн хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлын талаар Төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг зөрчиж баримт нотолгоогүй, холбогдох байгууллагаар тогтоогдоогүй, гүтгэлгийн чанартай, бодит байдалд үйл нийцэх мэдээллийг төрийн албан хаагчийн болон иргэний хувиар олон нийтэд мэдээлж төрийн албан хаагчийн өргөсөн тангаргаа няцсан...	2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Ёс зүйн хорооны 5 дугаар хуралдаанаар ХУД дэх МХХ-ийн Мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч Г.Цэцэгдэлгэрийн холбогдох асуудлыг хэлэлцүүлэн 05/05 дугаартай дүгнэлт гарсан. Г.Цэцэгдэлгэрт Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтыг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулсан
9	НД-ийн 1-р хороо, уурхайчдын 16-1 тоотод оршин суугч А.Цагаанчулуу	НД дэх МХХ-ийн дарга Ж.Ганзоригийн ёс зүйтэй холбоотой асуудал	НД дэх МХХ-ийн дарга Ж.Ганзориг нь 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдөр албан ерөөндөө Баасанжав гэгчид болон өөртөө согтууруулах ундаа хийж өгөөд тулгаад уух гэж байсан үйлдэл дээр нь таарсан.	2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Ёс зүйн хорооны 5 дугаар хуралдаанаар НД дэх МХХ-ийн дарга Ж.Ганзоригийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлэх явцад гомдол гаргагч А.Цагаанчулуу “Ж.Ганзориг нь ерөөндөө архи согтууруулах ундаа хэрэглэсэн асуудлаар цагдаад хандсан байгаа учир цагдаагийн газраас тухайн хэрэг шийдэгдтэл ёс зүйн хорооны хурлыг түр хугацаагаар хойшлуулах” хүсэлт гаргасан тул уг асуудлыг хэлэлцүүлэхийг түр түтгэлзүүлсэн.

10	Иргэн О.Оюунжаргал	СБД дэх МХХ-ийн боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Мөнх-Эрдэнэ	СБД дэх МХХ-ийн боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Мөнх-Эрдэнэ нь хүнийш загнаж, ёс бус аашилсан.	2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Ёс зүйн хорооны 5 дугаар хуралдаанаар СБД дэх МХХ-ийн боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Мөнх-Эрдэнэд холбогдох асуудлыг хэлэлцүүлэхэд ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүй болно.
11	БЗД-ийн 13-р хороо 127-4-24 тоотод оршин суугч Н.Лхагважав	ХНХТХХ-ийн Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Ч.Бүжинлхам	... хяналт шалгалтаар ирснийхээ дараа манай эхнэр лүү утсаар залган хэл амаар доромжилсон, хэт их гомдол гаргагч талыг барьж төрийн ажил хийж гүйцэтгэж байгаа байцаагчийг шалгаж үнэн зөвийг олж өгнө үү.	2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Ёс зүйн хорооны 5 дугаар хуралдаанаар ХНХТХХ-ийн Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Ч.Бүжинлхамд холбогдох асуудлыг хэлэлцүүлэхэд ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй болно.
12	Удирдлагын шийдвэрээр	БГД дэх МХХ-ийн улсын ахлах байцаагч С.Ариунцэцэг	Ёс зүйн зөрчилтэй гэх	2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Ёс зүйн хорооны 5 дугаар хуралдаанаар БГД дэх МХХ-ийн улсын ахлах байцаагч С.Ариунцэцэгт холбогдох асуудлыг хэлэлцүүлэхэд ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүй болно.
13	СХД 1-р хороо 68-9 тоотод оршин суугч Ц.Мөнхтуяа	ДБХХ-ийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч А.Цэцэгмаа, Ц.Цэнгэл, Харилцаа, холбооны хяналтын улсын байцаагч С.Шинэбаяр	2018 оны 05 дугаар сарын 23-ны өдөр өгсөн өргөдлийн дагуу шалгалт хийсэн улсын байцаагч нар нь өөрсдийн ажлыг хийхгүй байна гэх	2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар ДБХХ-ийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Ц.Цэнгэл, А.Цэцэгмаа, улсын байцаагч С.Шинэбаяр нарт холбогдох асуудлыг хэлэлцүүлэхэд тус гомдол нь Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 180200304 дугаартай мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа тул таны гаргасан гомдлыг хэлэлцүүлэхийг түр

				түтгэлзүүлсэн болно.
14	СБД 1-р хороо 12/2-23 тоотод оршин суугч М.Чаминцэцэг	ДБХХ-ийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Г.Вандандэмид	Ёс зүйн зөрчилтэй гэх	2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар ДБХХ-ийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Г.Вандандэмидэд холбогдох асуудлыг хэлэлцүүлэн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байх тул “Анхааруулах хуудас” хүргүүлсэн.
15	БЗД-ийн 5-р хороо ОТИС-ийн 3 тоотод оршин суугч Г.Үнэнбаяр	БЗД дэх МХХ-ийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч П.Төгсмаа, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Ц.Давхарбаяр	... миний нэр төрд халдаж доромжилж харьцсан гэх	2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар БЗД дэх МХХ-ийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч П.Төгсмаа, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Ц.Давхарбаяр нарт холбогдох асуудлыг хэлэлцүүлэхэд талууд эвлэрсэн.
16	НД-ийн 3-р хороо Нарангийн 9-480 тоотод оршин суугч Г.Баярмаа	НД дэх МХХ-ийн Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч И.Жавхлант	... манай ажлын байран дээр ирж намайг хэл амаар доромжилж, заналхийлсэн ... шалгаж арга хэмжээ авч өгнө үү	Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар НД дэх МХХ-ийн Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч И.Жавхлантад холбогдох асуудлыг хэлэлцүүлэхэд ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүй болно.
17	ХНХТХХ-ийн улсын байцаагч Б.Уянга улсын байцаагчийн үнэмлэх тэмдэгээ үрэгдүүлсэн тухай	ХНХТХХ-ийн улсын байцаагч Б.Уянга	... улсын байцаагчийн үнэмлэх тэмдэгээ үрэгдүүлсэн тухай	2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 6 дугаар хуралдаанаар ХНХТХХ-ийн улсын байцаагч Б.Уянгын асуудлыг хэлэлцүүлэн 06/06 дугаартай дүгнэлт гарсан.
18	ХУД дэх МХХ-		Одоогийн ажлын	2018 оны 10 дугаар

	ийн дарга Б.Алтантуяа		байранд тавигдах шаардлагад нийцсэн эсэх, ёс зүйн алдаа гаргасан байдал зэргийг шалгуулах	сарын 16-ны өдрийн 7 дугаар хуралдаанаар ЭАХХХ-ын улсын байцаагч Б.Очмаагийн асуудлыг хэлэлцүүлэн 07/07 дугаартай дүгнэлт гарсан.
19	ХУД дэх МХХ- ийн Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч А.Золзаяа	ХУД дэх МХХ- ийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Б.Очмаа		
20	ХУД дэх МХХ- ийн дарга Б.Алтантуяа	ХУД дэх МХХ- ийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч С.Долгор	Төрийн байгууллагын албан өрөөнд удирдлага руугаа дайрч двшилж, доромжилсон үйлдлийг ёс зүйн ноцтой зөрчил гэж үзэж байгаа тул шалгаж өгнө үү	2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 7 дугаар хуралдаанаар ЭАХХХ-ын улсын ахлах байцаагч С.Долгорын асуудлыг хэлэлцүүлэн 07/08 дугаартай дүгнэлт гарсан.
21	ХУД дэх МХХ- ийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Б.Очмаа	ХУД дэх МХХ- ийн дарга Б.Алтантуяа	Одоогийн ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн эсэх, ёс зүйн алдаа гаргасан байдал зэргийг шалгуулах	2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 7 дугаар хуралдаанаар ХУД дэх МХХ-ийн дарга Б.Алтантуяагийн асуудлыг хэлэлцүүлэн 07/09 дугаартай дүгнэлт гарсан.

Мөн ёс зүйн зөрчилтэй гэх 7 гомдлыг судлан ажиллах явцад талууд эвлэрсэн 1, ёс зүйн маргаан үүсгэх үндэслэлгүй 2, гомдлоос татгалзсан 2, харьяаллын дагуу 2 асуудлыг Дотоод хяналт, шалгалт, мониторингийн хэлтэс болон МХЕГ-ын Ёс зүйн хороонд тус тус шилжүүлсэн,

4. Архив, албан хэрэг хөтлөлт:

Ёс зүйн хорооны 2017 оны хурлын тэмдэглэл, дүгнэлт, үйл ажиллагаатай холбогдолтой тайланг архивын нэгж болгон хавтаслан архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн ба 2018 оны Ёс зүйн хорооны үйл ажиллагаатай холбогдолтой тайлан, хурлын тэмдэглэл, дүгнэлтийг архивын нэгж болгохоор бэлтгэн ажиллаж байна.

5. Судалж буй өргөдөл гомдол:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Авто замын хяналтын улсын ахлах байцаагч Д.Дуламрагчаад холбогдох “Астра вилла” Сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал Д.Ганбаатараас гаргасан “... улсын байцаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг шалгаж өгнө үү” гэх гомдол;

2. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга С.Даваасүрэн, Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Д.Дэлгэрмаа нарт холбогдох Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны иргэн Ш.Эрдэнэчимэгээс гаргасан “... улсын байцаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг шалгаж өгнө үү” гэх гомдлыг тус тус шалган судалж байна.